

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ
(Шинэжинст сум)**

2023 оны 12 дугаар сарын 25

Залаа

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9	10
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
1	1.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл	1.1.12. Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн засвар		Гүйцэтгэлийн хувь	100		Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн их засварын зураг төслийг "ЦЭСДА" ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн. Зарцуулагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн. Их засварын ажлыг "ПЛУТУС-ВЕЛТ" ХХК хийж гүйцэтгэхээр авсан. Одоогийн байдлаар дотор-1, гадна шилэн металл-1 хаалга, төмөр металл 5 хаалгыг тус тус хийсэн. 2024 онд их засварын ажлыг үргэлжлүүлэн хийхээр болсон.	100%	70%
2	1.5. Халамжаас-Хөдөлмөрт	1.5.1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх		Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	1310		2023 оны дугаар сарын 22-ний өдрөөс эхлэн нийт 15 оюутанг ЭрдэнэМонгол ХХК-тай хамтран цалинжуулж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгож, 3 сарын хугацаанд ажлын байраар хангаж ажилласан.	90%	90%

1	2	3	4	5	6	7	8	9	10
3	1.7. Хонгорын иргэн-Хонгорын баялаг	1.7.5. Алслагдсан сум, багийн малчдад зориулсан соёл хүмүүжлийн олон талт арга хэмжээ зохион байгуулах		Арга хэмжээ зохион байгуулсан сумын тоо	10	5 сая	Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Хонгорын иргэн Хонгорын баялаг уриа дор мянган малчдын дунд зохион байгуулагдсан спорт, урлагийн арга хэмжээнд тус сумын 4 багийн нийт 83 малчид соёл хүмүүжлийн арга хэмжээнд амжилттай оролцож ирсэн. Суманд зохион байгуулагдсан малчид төлчдийн зөвлөгөөн, намрын спартакиад, Залаагийн залуучууд чуулга уулзалт, эртэч залаажинстчүүд зэрэг арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 1000 гаруй иргэд 6 төрөл соёл хүмүүжлийн арга хэмжээнд хамрагдан байна.	100%	100%
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									
4	2.3. Эрүүл хөрс-Эрүүл хүнс	2.3.1. Сарлаг үхэр, баталгаажсан үйлдэр омгийн хээлтэгч малд шилэн сонголт хийх		Шилэн сонголтод хамрагдсан малын тоо /мянга/	11	1023000	Шинэжинст сумын мал сүргийн бог малын хээлтүүлэгчид мал зүйч С.Тэгшбаяр, улсын байцаагч Э.Бумбаяр нар хаврын ангилалтыг ялган суурилсан 2 суурьт Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч Б.Ганбатын хамт хийлээ. Цармын цагаан сувд хоршоогоор дамжуулан суманд бий болгосон цөм сүргийн ямаан сүрэгт намрын ангилалт хийх ажлыг тамгын газрын жолооч Ж.Шархүү, хөдөө аж ахуйн тасгийн дарга Б.Ганбат, Уртын гол 2 дугаар багийн иргэн Ш.Мөнх-Эрдэнэ, мал маллагчдын хамт 2023 оны 10 дугаар сарын 19, 21, 22-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Малчин Ш.Жигжидсүрэнгийн суурьт байсан 100 толгой эм ямаа, 25 толгой ишиг, 2 толгой ухныг үзлэг ангилалтад бүрэн хамрууллаа. Мөн цөм сүрэг маллагч Д.Батцэнгэл, Б.Отгонбаатар нарын сууриар орж 130 толгой эм ямааг үзлэг ангилалтад хамруулж бүртгэл хөтөллөө. Ямааны амьдын жингийн дундаж 32-41 кг, ишиг 19-21 кг-ийн дундажтай байлаа. Хуваарилагдсан шатахууныг бүрэн зарцуулж дууссан болно. Нийт 137 км замыг	100%	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10
							тууллаа. Ангилалтад нийт 263 толгой ямаа хамрагдлаа. Бог малын хээлтүүлэгчид ангилалт хийх ажлыг батлагдсан төсвийн хүрээнд сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хугацаанд нь зохион байгууллаа. Богийн хээлтүүлэгчийг ялган суурилж хариуцан маллаж байгаа Уртын гол багийн малчин М.Дөлгөөн, Зараа багийн малчин Цэрэнчимэд нарын сууриар орж, Эрдэнэшанд багийн малчид хээлтүүлэгчээ ялгаагүй тул өрхөөр орж ангилалтыг гүйцэтгэв. Намрын ангилалтад 501 толгой ухна, 180 толгой хуц хамрууллаа. Хаврын ангилалтаар 1 настай борлон ухнын амьдын жингийн дундаж 20,8 кг, 2-3 настай өсвөр ухнын амьдын жингийн дундаж 31 кг, 4 наснаас дээш настай бүдүүн ухнын амьдын жингийн дундаж 45,6 кг, 1 настай төлгөн хуцын амьдын жингийн дундаж 24 кг, 2-3 настай өсвөр хуцын амьдын жин 36кг, 4-өөс дээш настай бүдүүн хуцын амьдын жингийн дундаж 46,2 кг байв. Намрын ангилалтаар борлон ухнын амьдын жингийн дундаж 32 кг, 2-3 настай өсвөр ухнын амьдын жингийн дундаж 43-46 кг, бүдүүн ухнын амьдын жингийн дундаж 58-61 кг, төлгөн хуцын амьдын жингийн дундаж 36-38 кг байв.		
5		2.3.3. Шаардлагат ай сумдын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж худаг гаргах, засварлах		Шинээр гаргах худгийн тоо, засварласан худгийн тоо	7 1		Бэлчээрийн уст цэгийн хайгуул хийх /1-р баг/, Бэлчээрийн уст цэгийн хайгуул хийх /2-р баг/ ажлуудыг “Гео дата процессинг” ХХК-тай ажил тус бүр 7.0 сая, нийт 14.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн. Мөн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд 1, 2, 3-р баг тус бүрд бэлчээрийн худаг гаргахаар 60 сая төгрөгийн төсөвт тусган ажиллаж байна. НАРНЫ ӨРГҮҮРТЭЙ ХУДАГ АШИГЛАЛТАД ОРСОН “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн 30 сая	100%	100%


1	2	3	4	5	6	7	8	9	10
							төгрөгөөр 1 дүгээр багийн нутаг "Аман шүүт"-д бий болгож буй 8 төрлийн мод, бут сөөг, тэжээлийн ургамлын ургалтыг нэмэгдүүлэх зорилгоор энэ жил ОНХС-ийн 17500000 төгрөгийн санхүүжилтээр нарны өргүүртэй худаг байгуулан ашиглалтад орууллаа.		
ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
6	3.1. Эх байгаль-Ногоон байгууламж	3.1.2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх		Тарьсан модны тоо	500000		Байгууллагын хүрээнд нийт 60 гаран мод тарьж ургуулж байгаагаас ургахгүй байсан хөрс муудсан ургалт зогссон 12 модыг хөрсийг сийрэгжүүлэн дахин шинээр суулгаад байна. Хүн бүрд модыг хуваарилан өгч хурдан ургуулах тал дээр анхааран ажиллаж байна.	70%	70%
7		3.1.12. Эвент арга хэмжээ зохион байгуулж, оролцох		Гадаад, дотоод жуулчдын тоо	200 17000	15 сая	Тус сумын хэмжээнд эвент арга хэмжээ 6 удаа зохион байгуулагдсан байна. Аймгийн тэмээчдийн зөвлөгөөнийг бүсийн хэмжээнд Шинэжинст суманд зохион байгуулагдаж Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан, Богд, Жинст, Баянговь, Баянлиг сумдын хүрээнд болсон бөгөөд Өмнөговь аймгийн Гурвантэс, Баяндалай сумуудаас оролцож нийт 50 гаруй уяачид 700 гаруй үзэгчид цугларсан эвент арга хэмжээ болсон. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан мянган малчдын зөвлөгөөн 4 багийн 80 гаруй иргэд урлаг, спортын арга хэмжээнд оролцсон. Залаагийн жигүүр оюутан залуучуудын чуулга уулзалт болж нийт 100 гаруй залуучууд урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулж, орон нутгийн хөгжлийн талаар санал дэвшүүлсэн. Сумын нийт иргэдийн дунд Хөдөлгөөн ба эрүүл мэнд намрын спартакиад спортын арга хэмжээ зохион байгуулагдаж, түүний дагуу бүтээлч ажил нь орчны хог хаягдлыг бүх нийтээр цэвэрлэх ажил хийгдэж нийт 500 гаруй иргэд 25 тн хог хаягдлыг .	100%	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10
							цуглуулан 2 га гарыг цэвэрлэж ажилласан. Улсын баяр наадам болон 3 багийн нэрэмжит баяр наадмыг багууд зохион байгуулж ажилласан. Ээжүүдийн цагаан сүүний цацал, Залаа хайрхан, Бор хайрхан, Сэгс цагаан богд хайрхны тахилга зэрэг эвент арга хэмжээнүүд зохион байгуулагдаж нутгийн иргэдийн 80 хувь нь оролцдог уламжлал болсон ажлууд хийгдлээ.		
ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
8	4.1. Ээлтэй төлөвлөлт, эрсдэлгүй амьдрал	4.1.14. Шинэжинст сумын зам засвар		Гүйцэтгэлийн хувь	100		Аймгийн Засаг даргын Тамгын газраас нэгдсэн журмаар тендер зарлахаар санхүүжилт хүлээгдэж байна.	100%	0%
ЗУРГАА. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО									
9	6.1. Ухаалаг Засаглал	6.1.1. Иргэдэд зориулсан "Хамтдаа шийдье" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх		Хамрагдсан өрхийн тоо	5000		"Хамтдаа шийдье" аяны хүрээнд төрийн албан хаагчидтай хамтран "Хууль зүйн мэдээллийн цаг" Иргэдэд тулгамдаж буй эрх зүйн асуудал, татвар төлөлт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаар сумын төвд 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 2 сарын хугацаатайгаар нийт 18 удаагийн сургалтыг долоо хоногийн Пүрэв гараг бүр бусад төрийн албан хаагчтай хамтран зохион байгуулсан.	70%	70%
10		6.1.3.8. "Хүүхдэд ээлтэй орон нутаг" санаачилгын тогтвортой байдлыг хангах арга хэмжээний		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70	хувийн хэвшил	Тус сумын хэмжээнд хүүхдэд ээлтэй орон нутаг санаачилгыг хэрэгжүүлэх үүднээс сургуулийн дотуур байрын сурагчдын хоол үйлдвэрлэлийн орчныг сайжруулах чиглэлээр "Сэкер ресорсус Монголиа" ХХК-д санал тавьж ажилласнаар гал тогооны шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулж өглөө. ЭрдэнэМонгол ХХК өөрийн санхүүжилтээр сургуулийн хүүхдүүдэд зориулсан ариун цэврийн байгууламжийг бий	100%	70%

1	2	3	4	5	6	7	8	9	10
		2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх					болгож 4 эрэгтэй, 4 эмэгтэй нойлын өрөөтэй болгон ашиглалтад оруулсан. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр мод тарих, ажлыг хийлээ. Аймгийн уралдаан тэмцээнд бөх, гар бөмбөгийн төрлөөр оролцуулж амжилтууд удаа дараа гаргасан. Спорт, урлагийн төлбөртэй болон төлбөргүй секц дугуйлангууд тогтмол ажиллаж байна.		
11		6.1.3.11. "Хонгорын гэр бүл" зорилтот арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	55		Хонгорын гэр бүл зорилтот арга хэмжээний хүрээнд гэр бүлд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлууд тодорхой хэмжээгээр хийгдлээ. Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас мэргэжилтнүүд 2 удаа ирж сургалт хийсэн. Энэ сургалтад 28 өрхийн 68 иргэн хамрагдсан байна. Гэр бүлийн асуудлаар 3 иргэн зөвлөгөө авсан, өрх гэрийн амьдралд тодорхой өөрчлөлт нэмэр болж өгсөн.	70%	70%
12		6.1.4.6. Хөдөө аж ахуйн салбарт нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх /Оюутнуудын сургалтын төлбөрийн дэмжлэг/		Суралцагчийн тоо	19		1 оюутантай Аймгийн Хөдөө аж ахуйн газар, Сумын засаг даргын тамгын газар нар гурвалсан гэрээ байгуулж, 4 жилийн хугацаанд орон нутагт хэрэгцээт Мал зүйч мэргэжлээр суралцаж байна.	100%	100%
13	6.1. Ухаалаг Засаглал	6.1.7. Гамшгаас хамгаалах "Иж бүрэн", команд штаб, Засаг		Зохион байгуулсан үзлэгийн тоо, Оролцооны хувь	10, 80	5 сая	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн команд штабын үйл ажиллагааг хавар 2 удаа явуулахад хамт олноороо бүрэн дохио дуугарсан хугацаанд нь очиж жагсаж	100%	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10
		даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг зохион байгуулах					дээрээс ирсэн шийдвэрийг биелүүлэн ажилласан. алба, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах “Иж бүрэн” дадлага, сургууль зохион байгууллаа. Сумын Онцгой комисс, штабын удирдлагын харилцан ажиллагааг сайжруулах, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, сум, аж ахуй нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тодотголыг хийж, заавар, зөвлөмж өгөх, объектын болон ой хээрийн түймэр, Зоонозын халдварт өвчин, газар хөдлөлтийн гамшгийн тухай, аймгийн хэмжээнд тохиолдож буй аюулт үзэгдэл, ослын тухай урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ослын үеийн удирдлагын системийн тухай ойлголт, штабын дадлага зохион байгуулах нь зэрэг сэдвүүдээр танхимын сургалт орсон. Мэргэжлийн ангийн нийт 100 орчим бүрэлдэхүүнийг “Яаралтай цуглар” дохиогоор ажиллуулан бэлтгэл, бэлэн байдлыг шалгаж, хүн нэг бүрийн бэлэн байдлын үүргэвчинд үзлэг хийж, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг жигдрүүлж үнэлгээ дүгнэлт өгөв. Сумын Засаг даргын 2023 оны А/29 дүгээр захирамжаар байгуулагдсан сайн дурын хэсгүүдийн бүрэлдэхүүнд объектын гал түймэр унтраах, аврах ажиллагааг зохион байгуулах багаж хэрэгслийг ажиллуулах талаар сурган зааварлаж, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, түймрийн голомтод хэрхэн ажиллах талаар дадлага, сургуулилт хийж арга зүйн зөвлөгөөгөөр хангалаа. Мөн сумын “Хүн эмнэлэг”-ийг зоонозын халдварт өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дуурайлган үзүүлэх дадлага сургуулийг зохион		

ХЯНАСАН
 ЗАСАГ ДАРГЫН ТАНГЫН ГАЗРЫН
 ДАРГА *Орм* Л.БАТХҮҮЯГ
 БИЕЛЭЛТ ГАРТАСАН
 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
 МЭРГЭЖИЛТЭН *Т.Дамтсүрэн* Г.БАТЧИМЭГ



1	2	3	4	5	6	7	8	9	10
							байгуулж удирдлага, сайн дурын хэсгүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэн ажиглалаа.		

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ
 ЖИЛИЙН ЭЦСИН ХЭРЭЖИЛТИЙН ТОВЧОО
 (Өөрийн үнэлгээ)

2023 оны 12 дугаар сарын 25

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИН ХЭРЭЖИЛТИЙН ТОВЧОО		
Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 13		
Үр дүнтэй	100%	9
Тодорхой үр дүнд хүрсэн	70-90%	4
Эрчимжүүлэх шаардлагатай	30-50%	-
Үр дүнгүй	0%	-
Хэрэгжих хугацаа болоогүй	Х.Б	-
Аймаг, нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт 92,3% хувьтай байна.		

Залгаа

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ
 ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО
 (Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2023 оны 12 дугаар сарын 25

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО		Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 13	
Үр дүнтэй	100%	6	6
Тодорхой үр дүнд хүрсэн	70-90%	6	6
Эрчимжүүлэх шаардлагатай	30-50%	-	-
Үр дүнгүй	0%	1	1
Хэрэгжих хугацаа болоогүй	Х.Б	-	-
Аймаг, нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт 80% хувьтай байна.			